



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН ИННОВАЦИЙН ХӨТӨЛБӨР

/2018-2030 ОН/

Улаанбаатар хот
2018 он

АГУУЛГА

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ 3
2. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ 4
3. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА 6
4. ХӨТӨЛБӨРИЙН ҮР НӨЛӨӨ, ТҮҮНИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ 6
5. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ, САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР 7
6. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА, ХАМРАХ ХҮРЭЭ

Монгол Улс инновацийн үйл ажиллагааг дэмжин хөгжүүлэх зорилгоор 2007 онд Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр, 2010 онд Төрөөс өндөр технологийн аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого, 2012 онд Инновацийн тухай хуулийг батлан хэрэгжүүлж ирсэн. Дээрх хууль, бодлогод тулгуурлан “Зам, тээврийн салбарт инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр”-ийг боловсруулсан Зам, тээврийн сайдын 2015 оны ... дугаар тушаалаар батлан хэрэгжилтийг ханган ажилласан. Тус яамнаас ... дугаар тушаалын хэрэгжилтийг ханган ажиллаж, дэд салбарын инновацийн ажлын төлөвлөгөөг боловсруулж, авто тээврийн инновацийн өдөрлөг, арга хэмжээг жил бүр зохион байгуулж ирсэн.

Инновацийн тухай хуулийн 6.1.1, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.29-д заасны дагуу “Төрөөс инновацийн талаар баримтлах бодлого” Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн 233 дугаар тогтоолоор батлагдан гарлаа. Уг бодлогын баримт бичигт өрсөлдөх чадварыг бэхжүүлэх, судалгаа боловсруулалтын ажлын үр дүнг үйлдвэрлэл, бүтээгдэхүүн, үйлчилгээнд нэвтрүүлэх, инновацийн соёлыг түгээн дэлгэрүүлэх зэрэг асуудлыг 2018-2025 онд хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Энэхүү төрөөс баримтлах инновацийн бодлоготой уялдуулан “Зам, тээврийн салбарын инновацийн хөтөлбөр”-ийг шинэчлэн боловсрууллаа. Монгол Улсын зам, тээврийн салбарт үр ашигтай дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор бүтээгдэхүүн, үйлчилгээ, маркетингийн инновацийн үйл ажиллагааг уг хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэхээр тусгалаа.

Улс орны хөгжлийг замгүйгээр төсөөлөх боломжгүй, түүний дотор Монгол орны ачаа тээврийн 65%, зорчигч тээврийн 98%-ийг авто тээврээр гүйцэтгэж байгаа энэ үед аюулгүй, ая тухтай, авто замаар үйлчлэх нь авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын гол бодлого юм.

Шинжлэх ухаан, техник технологи, аж үйлдвэржүүлэлт нь хүн төрөлхтний амьдралд асар ихээр нөлөөлөхөөс гадна байгаль орчны болон экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулах үйл явцыг хурдасгадаг.

Харин замаа оновчтой төлөвлөн, технологийн дагуу зөв барьж байгуулах үйл ажиллагаа нь барилгын ажлын явц дахь байгаль орчны багахан хэмжээний сөрөг нөлөөллийг эс тооцвол түүнээс үүдэн гарах сөрөг үр дагавар бараг үгүй гэж үзэж болно.

Үүнээс гадна Дэлхий нийтэд тулгараад байгаа уур амьсгалын өөрчлөлт, эдийн засаг, хүн ам, ахуйн хэрэглээний хурдацтай өсөлт нь байгалийн нөөцийг хомсдуулж, дэлхийн хүрээлэн буй орчны тогтолцоог тогтвортойгоор оршин тогтноход эрсдэл учруулж байгаль экологид сөрөг нөлөөлөл үзүүлж байна. Иймд улс орон, иргэн бүр өөрийн ахуй амьдрал, хэрэглээ, аж үйлдвэрийн хөгжлийн чиг хандлага болон байгаль орчин, экологийн боловсролын бодлогоо эрс өөрчилж хүрээлэн буй орчинд ээлтэй, тогтвортой ногоон хөгжлийн баримжаа бүхий нийгмийн тогтолцоонд шилжих шаардлагатай болоод байна.

НҮБ-ын тогтвортой хөгжлийн дээд хэмжээний уулзалтууд нь дэлхийн байгаль орчны тулгамдаад байгаа асуудлууд, ядуурлыг бууруулах, ногоон эдийн засаг, тогтвортой нийгмийн тогтолцоог улс орон бүр өөрийн онцлогт тохируулан хөгжүүлэх

талаар бодлогын баримт бичиг, тайлан, зөвлөмжүүд гаргасаар байна. Үүний дагуу улс бүр байгалийн нөөц баялагаа үр ашигтай ашиглан орчны бохирдол доройтлоос хамгаалах, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай үйлдвэрлэл, хэрэглээг дэмжих, тогтвортой нийгмийг цогцлооход чиглэсэн үзэл баримтлал, бодлого стратеги, хөтөлбөрүүдээ хэрэгжүүлж байна.

Монгол Улсын хувьд газар нутгийн дийлэнх хэсэг байгалийн унаган байдлаа харьцангуй хадгалсан хэдий ч уул уурхайн салбарт түшиглэсэн эдийн засгийн өсөлт, аж үйлдвэржилт, байгаль орчны бохирдол ба доройтол, биологийн олон янз байдал устах зэрэг асуудлууд тогтвортой хөгжилд сөргөөр нөлөөлөх үндсэн хүчин зүйлс болоод байна.

Монгол улсын эдийн засгийн гол салбар зам, тээврийн тулгамдсан асуудлуудыг цогцоор нь шийдэхэд инновацийн хөтөлбөрийг боловсруулан тодорхой үе шаттайгаар хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага манай өнөөгийн нийгэмд бий болсон байна.

Монгол улсын Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх бодлогын хүрээнд дэлхийн хөгжингүй болон өндөр хөгжилтэй орнуудын шилдэг туршлагыг тусгасан, цоо шинэ үзэл санааг:

- Зам, тээврийн технологи дахь инноваци;
- Зам, тээврийн инновацийн санаа;
- Зам, тээврийн инновацийн систем;
- Зам, тээврийн үйлдвэрлэлийн инноваци зэрэг хөгжингүй орнуудын зам, тээврийн салбарын инновацийн тэргүүн туршлагыг судалж манай орны онцлогт тохирох зарим санааг тусгасан хэрэгжүүлэх бүрэн боломжтой юм.

Инновацийг амжилттай хөгжүүлж буй улс орнуудын адил нийгэмд тогтвортой дэд бүтцийг бий болгон, тогтвортой үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэн тогтвортой амьдралын хэв маягийг төлөвшүүлэхийн тулд шинэ техник технологи нэвтрүүлэх, байгаль орчинд ээлтэй гарааны бизнес загварыг хөгжүүлэх, институцуудын оролцоог нэмэгдүүлэх арга замаар зам, тээврийн салбарын инновацийн дэд хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж, Монгол улсын ирээдүйн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэхийн хамт бүс нутгийн болон дэлхийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулна.

2. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Монгол Улсын зам, тээврийн салбарт бүтээгдэхүүн, процесс, маркетинг зохион байгуулалтын инновацийн нэвтрүүлэх замаар байгальд ээлтэй техник, технологийг нутагшуулах, дэд бүтцийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

Хөтөлбөрийн зорилгын хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ:

➤ Зам тээврийн салбарын бүтээн байгуулалтын болон бусад үйлдвэрлэл, үйлчилгээ, бүтээгдэхүүн, үйл ажиллагаандаа байгальд ээлтэй техник, технологийг нутагшуулах;

- Авто замын салбарт хөрсийг органик болон органик бус материалаар бэхжүүлж, замын суурь үеийг барих эко технологи нэвтрүүлэх арга замын судалгаа;

- Агаарын бохирдлыг бууруулахад дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, шинэ санал, санаачилга гаргасан хувь, хүн аж ахуйн нэгж, байгууллагын оновчтой шийдлийг бодлогоор дэмжиж, нэвтрүүлэх арга хэмжээ авах;
- Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг төр, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн нэгдмэл үйл ажиллагаагаар хэрэгжүүлэх;
- Нисэхийн авионикийн технологийн сургалтыг боловсронгуй болгох судалгаа хэрэгжүүлж, нэвтрүүлэх;
 - Зам тээврийн салбарын бүтээн байгуулалтад өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх;
- Монгол орны зам цаг уурын нөхцөлд тохирсон битумын хэрэглээг нэвтрүүлэх замаар зам барилгын ажлын чанарыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх;
- Замын дагуух ус зайлуулах байгууламжийн оновчтой системийн нэвтрүүснээр замын техник ашиглалтын байдлыг дээшлүүлэх;
 - Зам тээврийн салбарын бүтээн байгуулалтын болон бусад үйлдвэрлэл, бүтээгдэхүүн, үйл ажиллагаа, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх.
- Биологийн олон янз байдал, ашигт ургамал, ховор, нэн ховор, ховордсон ан амьтдыг хамгаалах, нөөцийг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд ховор, нэн ховор ан амьтдын амьдрах орчныг сэргээн сайжруулж, тоо толгойг өсгөхөд төрийн болон олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, улсын болон орон нутгийн чанартай авто зам, төмөр замын дагуух зэрлэг амьтдын стандарт гарцыг барьж байгуулах;
- Зам, замын байгууламжийн үндэсний стандарт, техникийн норм баримт бичгүүдийг зам цаг уур амьсгалын судалгааны мэдээллийг тусган боловсруулах;
- Зам, тээврийн салбарын хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох;
- Аюулгүй, найдвартай, шуурхай аливаа үйлдвэрлэл, үйлчилгээ, нэвтрүүлэхэд чиглэсэн эдийн засгийн хөшүүргийг боловсруулж хэрэгжүүлэх;
- Авто замын салбарт хүйтэн, бүлээн асфальтобетон хучилт нэвтрүүлсэнээр гадаадын импортын битумын хэрэглээг бууруулж, эрчим хүчний хэмнэлтийг багасган, барилгын ажлын технологийн гормын шинэжлэл хийх замаар хөдөлмөр зарцуулалтыг багасгах боломжийг бүрдүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох.



3. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРЧИМ:

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална:

- ❖ үндэсний аюулгүй байдал, хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх;
- ❖ шинжлэх ухаан, технологийн сүүлийн үеийн дэвшилтэт ололтыг ашигласан, **инновацийн хөгжлийн тэргүүлэх чиглэл, инжлэх ухааны талаар төрөөс баримтлах бодлоготой уялдсан** байх;
 - ❖ эдийн засаг, нийгмийн **үр өгөөжид үндэслэх**;
 - ❖ төрийн дэмжлэг нь ил тод, шударга, нээлттэй байх;
 - ❖ иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тэгш эрхтэй, чөлөөтэй оролцох;
 - ❖ **Тогтвортой хөгжил чиг хандлагад нийцсэн байх**;
 - ❖ **Зам, тээврийн салбарын бодлогын харилцан уялдааг хангах**;
 - ❖ **Үйлдвэрлэлийн технологийн хөгжил, судалгаа хөгжүүлэлтийн түвшинг харгалзах**;
- ❖ Үйл ажиллагаанд оролцогч талуудын хамтын ажиллагаа, харилцан ашигтай түншлэлд тулгуурлах;

4. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хөтөлбөрийг хоёр үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

-  нэгдүгээр үе шат: 2018-2021 он
-  хоёрдугаар үе шат: 2022-2025 он

5. ХӨТӨЛБӨРИЙН ҮР НӨЛӨӨ, ТҮҮНИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр нийгэм, эдийн засгийн хөгжилд дараах үр нөлөөг үзүүлнэ:

5.1 Эдийн засгийн хөгжилд үзүүлэх үр нөлөө:

5.1.1 Салбарт бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн чанар, хүртээмж, нэр төрөл нэмэгдсэнээр эдийн засгийн чадавх, үр ашиг дээшилнэ.

5.1.2 Салбарын төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын хэмжээ өснө.

5.1.3 Их, дээд сургууль, судалгааны төвүүдийн чадамж дээшилнэ.

5.1.4 Салбарт өндөр үр ашиг, хэмнэлт бүхий дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, нутагшуулах нөхцөл бүрдэнэ.

5.2 Нийгмийн хөгжилд үзүүлэх үр нөлөө:

5.2.1 Салбарын өрсөлдөх чадвар дээшилнэ.

5.2.1 Салбарт инноваци нэвтрүүлэхтэй холбоотойгоор гааль, татвар, зээлийн бодлогоор дэмжсэнээр инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйлдвэрлэлийн чанар, хүртээмж дээшилнэ.

5.2.2 Инновацийг хөгжүүлэхтэй холбоотой хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, дэд бүтэц байгуулах, хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалт хийх зэргээр төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүртэх боломж бүрдэнэ.

5.2.3 Инновацийн соёлыг түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн танин мэдэхүйн төрөл бүрийн контент бий болсноор нийгэмд инновацийн соёл төлөвшинэ.

5.2.4 Инкубатор төв, хамтын оффисуудад сургалт, зөвлөх үйлчилгээ, зорилтот арга хэмжээг зохион байгуулснаар хүний нөөцийн чадавх бэхжинэ.

5.2.5 Гадаадад инноваци, өндөр технологийн чиглэлээр ажиллаж, амьдарч буй өндөр мэдлэг чадвартай гадаад, дотоодын мэргэжилтэн, судлаач, инженерүүдийн тоо нэмэгдэж, салбарын өрсөлдөх чадвар дээшилнэ.

5.2.6 Өндөр технологийн салбаруудыг хөгжүүлсэнээр эдийн засаг, хөрөнгө оруулалт сайжирч, иргэдийн амьдралын чанар дээшилнэ.

5.3 Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө:

5.3.1 Байгаль орчинд ээлтэй технологи, тоног төхөөрөмж бүхий инновацийн дэд бүтэц бий болно.

5.3.2 Байгальд сөрөг нөлөөгүй бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээ нэмэгдэнэ.

5.3.3 Салбарт ногоон технологийн хэрэглээ өснө.

5.3.4 Эко үйлдвэрлэл, үйлчилгээ, бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ өснө.

ШАЛГУУР ҮНЭЛГЭЭ

Холбогдох үзүүлэлтүүд		2018 он	2021 он	2025 он
Инновацийн санхүүжилт	Инновацид зориулсан санхүүгийн нийт дэмжлэг (ДНБ-д эзлэх хувиар)	-	10%	18%
	Инновацийн үйл ажиллагааны чиглэлээр судалгаа хөгжүүлэлтийн ажил эрхэлж буй нийт боловсон хүчин, судлаачид (Нийт ажиллах хүчинд эзлэх хувиар)	-	5.7%	8.5%
Инновацийн үйл ажиллагаа	Инновацийн үйл ажиллагаа дагнан эрхэлж буй компаниудын тоо	2	15	30
	Инновацийн гарааны компаний тоо	-	3	5
	Инновацитай холбоотой менежментийн тогтолцоог хэрэгжүүлсэн компанийн тоо	-	20	45
Инновацийн бүтээгдэхүүн	Инновацийн патент	-	8	15
Эдийн засаг, нийгмийн хөгжилд үзүүлсэн үр нөлөө	Инновацийн үйлдвэрүүд дэх ажил эрхлэлт	-	N/C	N/C
	Инновацийн зах зээлийн хэмжээ	-	N/C	N/C
	Инновацийн бүтээгдэхүүний экспорт	-	N/C	N/C
Байгаль орчинд үзүүлсэн үр нөлөө	Түүхий эдийн хэмнэлт (ДНБ/Түүхий эдийн нийт хэрэглээ, төг/тн)	-	N/C	N/C
	Хүлэмжийн хийн ялгарлын эрчим (CO ₂ /ДНБ, тн/төг)	-	N/C	N/C

ТАВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР

4.1. Хөтөлбөрийг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

- 4.1.1. Улсын төсөв;
- 4.1.2. Гадаадын зээл, тусламж;
- 4.1.3. Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт;
- 4.1.4. Концессын гэрээ;
- 4.1.5. Бусад эх үүсвэр.

ЗУРГАА. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

6.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг инновацийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, бусад яам, агентлаг, харьяа байгууллагатай хамтран зохион байгуулна.

6.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад зохих журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

-----oOo-----